



I/2022


Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 11



Төлбөрийн тэнцэл 2022 оны 1 дүгээр сард 340.9 сая америк долларын алдагдалтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 402.7 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 350.7 (7.7 дахин) сая америк доллароор өсжээ. Уг өсөлтөд барааны худалдааны алдагдал 251.5 сая америк доллароор, анхдагч орлогын алдагдал өмнөх оны мөн үеэс 60.8 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. УРСГАЛ ДАНС, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2022 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 52.0 сая америк доллар, зарлага 170.2 сая америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 9.0 сая америк доллароор буурсан бол зарлага 33.9 сая америк доллароор өссөн байна. Үйлчилгээний худалдааны алдагдал 2022 оны 1 дүгээр сард, өмнөх оны мөн үеэс 42.9 сая америк доллароор өсөж, 118.2 сая америк доллар болжээ.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, салбараар, сая америк доллароор

Үзүүлэлт	2020	2021*		2022*
	I	I	XII	I
Үйлчилгээ	- 132.5	- 75.4	- 1 380.3	- 118.2
Кредит	88.0	61.0	766.3	52.0
Дебит	220.5	136.3	2 146.5	170.2
Тээвэр	- 8.9	- 5.9	23.5	- 12.6
Кредит	53.5	40.3	521.5	33.8
Дебит	62.4	46.3	498.0	46.4
Аялал	- 86.2	- 32.1	- 545.0	- 40.0
Кредит	13.4	0.8	20.3	1.9
Дебит	99.7	32.9	565.3	41.9
Бусад үйлчилгээ	- 37.4	- 37.3	- 858.8	- 65.6
Кредит	21.0	19.8	224.4	16.3
Дебит	58.5	57.1	1 083.2	82.0

Хөрөнгийн данс 2022 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 3.4 сая америк доллароор буурчээ.

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны 1 дүгээр сард 73.1 сая америк долларын алдагдалтай байсан бол 2022 оны 1 дүгээр сард, өмнөх оны мөн үеэс 179.4 сая америк доллароор өсөж, 106.2 сая америк долларын ашигтай гарчээ.

ХҮСНЭГТ 2. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
сая америк доллароор

Үзүүлэлт	2020	2021*		2022*	Төлбөрийн тэнцэл 2022 оны 1 дүгээр сард 340.9 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 180.2 сая америк доллароор өсжээ.
	I	I	I-XII	I	
Урсгал данс	- 254.4	- 52.0	- 1 959.0	- 402.7	
Хөрөнгийн данс	8.0	9.5	126.5	6.1	
Санхүүгийн данс	- 110.2	73.1	- 1 835.1	- 106.2	
Алдаа болон орхигдуулга	45.6	- 45.1	- 224.3	- 50.6	
Нөөц хөрөнгө	- 90.7	- 160.7	- 221.6	- 340.9	

Ойлголт, тодорхойлолт

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна.

Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед “+” буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед “-” буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт: Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



Эх үүсвэр:

Монголбанк

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын,
Мөнгө санхүү, үйлчилгээний статистикийн
хэлтсийн статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212